



Аудитын код: YAG-CAГ-2018/158/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740 Цахим хаяг: Tsegmiddorjd@audit.gov.mn

Голден пэйж аудит ХХК

Захирал С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Аудитор Б.Одгэрэл
Утас: 70117179 Цахим хаяг: odgerel@goldenpageaudit.mn



Улаанбаатар хот

АГУУЛГА

1. Аудитын гэрчилгээ	1
2. Аудитын тайлан.....	1
2.1 Оршил.....	1
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5 Дотоод хяналт	3
2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7 Шилэн дансны мэдээлэл.....	3
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1 Худалдан авалтын талаар.....	4
2.9.2 Орлогын талаар.....	4
2.9.3 Үндсэн хөрөнгийн талаар.....	4
2.9.4 Мөнгөн хөрөнгийн талаар.....	4
2.9.5 Амралтын олговрын талаар.....	5
2.9.6 Хариуцлагын талаар	5
2.9.7 Музейн үзмэрийн талаар.....	6
2.9.8 Цалин хөлсний талаар	6
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	7
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал.....	8
3.1 Худалдан авалтын талаар.....	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16



МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Д.НАРАНЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын театрын музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол, Монголын театрын музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын театрын музейн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

- Төлбөртэй үйлчилгээний орлогыг бүртгэлд тусгаж тайлагнаагүй. Музейн тасалбар, үнэт цаасны тайлан гаргаагүй. Тайлант онд тус музейд байгууллага, иргэдийн гэрэл зураг, хувийн архив, дурсамж үзэсгэлэн 9 удаа, номын нээлт 6 удаа, хэвлэлийн бага хурал 2 удаа зохиогдсон боловч талбайн түрээсийн орлогыг бүртгэлд тусгаж тайлагнаагүй. Мөн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг дээр очиж хүүхэлдэйн тоглолт үзүүлсэн, бэлэг дурсгалын зүйл, ил захидал, судалгааны бүтээл борлуулсан, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд музейн үзмэрийн талаар материал бэлдэж өгч, бичлэг хийлгэж нэвтрүүлэг бэлтгэсэн, бичлэг хуулж өгсөн, гэрэл зураг хуулбарлан өгсөн зэрэг орлогыг бүртгэж тайлагнаагүй;
- Тайлант онд засварын ажлын харьцуулсан тендерээр 20,450.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан боловч уг хөрөнгүүдийг бүртгэлд тусгаагүй;
- Тайлант онд нийт 60,090.7 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 3,294.7 мянган төгрөгийн НӨАТ-ын цахим баримт бүрдүүлж, 56,795.9 мянган төгрөгийн худалдан авалтад НӨАТ-ын цахим баримт бүрдүүлээгүй;
- Музейн тасалбарын орлогыг өлгүүрчин бэлнээр хүлээн авдаг, кассын дэвтэр хөтлөөгүй, тайлан гаргаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй;
- Холбогдох тушаал шийдвэргүйгээр 2,676.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон;
- Амралтын олговрыг буруу тооцоолсноос 1,584.7 мянган төгрөгийг илүү олгосон;
- Музейн сан хөмрөгт хадгалагдаж байсан данс бүртгэлгүй эд зүйлийг эзэнд нь буцаан өгсөн;
- Сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд жилд дөрвөн удаа хүргүүлэх ёстой бүртгэл мэдээллийн сангийн тайланг нэг удаа хүргүүлсэн;
- Хандиваар ирсэн соёлын өвийг үнэлж хүлээн авдаггүй;
- Улсын болон соёлын өвийн тооллого хийгдээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байдал, үнэлгээ, хэмжилт, толилуулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Монголын театрын музейн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Наранжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд худалдан авалтад НӨАТ-ын цахим баримт бүрдүүлэн ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын театрын музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монголын театрын музейн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 1-нээс 2018 оны 2 дугаар сарын 9-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Голден пэйж аудит ХХК-ийн аудитын баг гүйцэтгэв.

Аудитаар Монголын театрын музейн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголын театрын музейн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 тоот албан бичгээр Голден пэйж Аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монголын театрын музей нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д “музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна” гэж тодорхойлсон.

Монголын театрын музейн үйл ажиллагааны зорилго:

- Урлаг соёлын өвийг хадгалж хамгаалан, хойч үедээ уламжлуулж, иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах, улмаар нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхэд оршино.
- **Үйл ажиллагааны стратегийн зорилт:**

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгын хүрээнд 2025 он гэхэд Монголын соёл урлаг, 3D үзүүлэлийн тэргүүлэх чиглэлийн музей болохын тулд доорх зорилтуудын хүрээнд ажиллаж байна. Үүнд:

- 2018 онд Монголын театрын музейн шинэ барилгын газрыг Улаанбаатар хотын захирагч, ерөнхий менежертэй ярьж шийдвэрлэх;
- 2019 онд гадны хөрөнгө оруулагч хайх, хамтарч ажиллах, 2020 он гэхэд төслийг хэрэгжүүлж эхлэх;

Монголын театрын музей үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монголын театрын музейн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 29 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/



Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Монголын театрын музейн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Монголын театрын музей нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монголын театрын музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүйгээс, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монголын театрын музей нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 150,525.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 150,525.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн ерөнхийлөн захирагчаас 32,350.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт батлагдсанаас 32,350.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 2,158.0 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөснийг 100 хувь биелүүлэн ажилласан байна.

Урсгал зардалд 152,683.3 мянган төгрөг батлагдсанаас 185,031.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Монголын театрын музей нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт зэрэг мэдээллийг оруулсан. Өмнөх оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт болон 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг оруулаагүй байна. Мөн хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг оруулаагүй байна. Шилэн дансанд нийт 150 мэдээ оруулах ёстойгоос 145 мэдээг оруулсан байна. Хугацаа хоцорч оруулсан 58 мэдээ, хугацаандаа оруулсан 87 мэдээ байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон ЭРСДЭЛ, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 29 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах”

гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Худалдан авалтын талаар

Тайлант онд нийт 60,090.7 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 3,294.7 мянган төгрөгийн НӨАТ-ын цахим баримт бүрдүүлж, 56,795.9 мянган төгрөгийн худалдан авалтад НӨАТ-ын цахим баримт бүрдүүлээгүй байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, НӨАТ-ын тухай хуульд зааснаар анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.9.2 Орлогын талаар

Төлбөртэй үйлчилгээний орлогыг бүртгэлд тусгаж тайлагнаагүй. Музейн тасалбар, үнэт цаасны тайлан гаргаагүй. Тайлант онд тус музейд байгууллага, иргэдийн гэрэл зураг, хувийн архив, дурсамж үзэсгэлэн 9 удаа, номын нээлт 6 удаа, хэвлэлийн бага хурал 2 удаа зохиогдсон боловч талбайн түрээсийн орлогыг бүртгэлд тусгаж тайлагнаагүй. Мөн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг дээр очиж хүүхэлдэйн тоглолт үзүүлсэн, бэлэг дурсгалын зүйл, ил захидал, судалгааны бүтээл борлуулсан, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд музейн үзмэрийн талаар материал бэлдэж өгч, бичлэг хийлгэж нэвтрүүлэг бэлтгэсэн, бичлэг хуулж өгсөн, гэрэл зураг хуулбарлан өгсөн зэрэг орлогыг бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүх орлогыг бүртгэж тайлагнах талаар албан шаардлага өгөх.

2.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант онд засварын ажлын харьцуулсан тендерээр 20,450.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан боловч уг хөрөнгүүдийг бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуульд заасны дагуу хөрөнгийг бүртгэж тайлагнах талаар албан шаардлага өгөх.

2.9.4 Мөнгөн хөрөнгийн талаар

Музейн тасалбарын орлогыг өлгүүрчин бэлнээр хүлээн авдаг, кассын дэвтэр хөтлөөгүй, тайлан гаргаагүй, үнэт цаасны тайлан тооцоо хийгээгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2012.12.21-ны 276 тоот "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.2-т "Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ", 7.2-д "Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах талаар албан шаардлага өгөх.

2.9.5 Амралтын олговрын талаар

Амралтын цалинг тооцоолохдоо унаа хоолны нэмэгдлийн дүн болон өмнөх амралтын цалингийн дүнг оруулан тооцсоноос 1,584.7 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь НХХСайдын 2005 оны 55 дугаар тушаал "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 4-д "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн тэтгэмжүүд, нөхөн олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дундаж цалин хөлс тодорхойлох журмын дагуу амралтын олговрыг зөв тооцоолж олгох талаар албан шаардлага өгөх.

2.9.6 Хариуцлагын талаар

2017.03.24-ны өдөр музейн захирлын А/09 тоот тушаалаар музейн сан хөмрөгт хадгалагдаж байсан данс бүртгэлгүй 3 ширхэг эд зүйлийг эзэнд нь буцаан өгсөн байна.

Энэ нь Музейн талаар Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2016 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 18 тоот тогтоолоор баталсан "Монгол улсын стандарт"-ын 12.5.4-д "Худалдах, түр хадгалах зэрэг тухайн музейн зорилгод нийцэхгүй зүйлийг сан хөмрөгт хадгалахгүй", 12.6.2-д "Музейд авсан үзмэр, эд зүйлийг буцааж олгохгүй" гэж заасныг зөрчсөн байна.

Тус музей нь 2017.03.03-нд Ерөөлч, магтаалч, туульч Э.Баатаржаваас товшуур, задын чулуу, хулсан хуур, модон морь зэрэг 6 үзмэрийг үнэ төлбөргүй авсан, 2017.12.11-нд 3 ширхэг хөрөг зураг, Радуга-2 кино проектор, Украина кино проектор, "Тэмээн сүргийн говь" хөшөөний загвар зэргийг хандиваар авсан боловч бүртгэлд тусгаагүй тайлагнаагүй байна.

Энэ нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т "Нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөл тодорхойлно", 9.3-д "хувийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээг өмчлөгчийн хүсэлтээр энэ хуулийн 9.2-т заасны дагуу тодорхойлж болно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох стандартыг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөх.

2.9.7 Музейн үзмэрийн талаар

Сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд жилд дөрвөн удаа хүргүүлэх ёстой бүртгэл мэдээллийн сангийн тайлангаа нэг удаа хүргүүлсэн, улсын тооллого 2013 оноос хойш хийгдээгүй байна.

Энэ нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “байгууллагын бүртгэл мэдээллийн сан нь жилд дөрвөн удаа сум, дүүргийн, сум дүүргийн бүртгэл мэдээллийн сан нь жилд хоёр удаа аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлийн бүртгэл мэдээллийн сан нь жилд нэг удаа улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд тус тус тайлангаа хүргүүлнэ”, 26 дугаар зүйлийн 26.1-д “соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна” гэж заасныг зөрчсөн байна. гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөх

2.9.8 Цалин хөлсний талаар

Холбогдох тушаал шийдвэргүйгээр 2,676.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-д “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх” гэж заасныг зөрчсөн байна.


Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал нь музейд үзмэрийг үнэ төлбөргүй хүлээн авдаг асуудал юм. Иргэд хувийн өмчийн соёлын биет өвөө үнэ төлбөргүй бэлэглэлийн гэрээгээр өгч ашиглуулчихаад хожим нь үнэ цэнэ нь өссөний дараа /сурталчилгаа хийлгүүлэн, хадгалуулчихаад/ тодорхой хугацаанд төрөөс зардал гарсны дараа ирээдүйд нэгэн цагт төрөөс маш өндөр үнэ цэнэ нэхэх эрсдэлтэй байна.

Энэ нь Монгол Улсын “Соёлын тухай” хуулийн 4 дүгээр зүйл “Соёлын талаарх иргэний эрх, үүрэг”-т заасан үндэсний болон дэлхий нийтийн соёлын үнэт зүйлтэй танилцах, тэдгээрийн үр шимийг хүртэх, ёс заншил, түүх, соёлыг өвлөн хөгжүүлэх, өвлөх, өвлүүлэх гэсэн заалтыг үндэслэн үнэ төлбөргүй өгсөн зүйлийнхээ үр шимийг эргэн нэхэмжлэх үндэслэлтэй.

Тус театрын музей нь урлаг соёлын өв түүхийг хойч үедээ уламжлуулан соён гэгээрүүлэх, ард иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах, нийгмийг соён гэгээрүүлэх үйлсэд үр ашгаа өгөх зорилготой, чиг үүрэгтэй тул энэ үүднээс төсвөөс санхүүжилт авч үйл ажиллагаа явуулах бус харин аж ахуйн тооцоон дээр үндсэн үйл ажиллагаанаасаа орлого олж түүгээрээ санхүүжиж ажиллах боломжийг холбогдох дээд шатны байгууллага судалгаа шинжилгээ хийж үзэх нь зүйтэй.



Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Соёлын байгууллагыг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх” бүрэн эрхийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэж заажээ. Мөн хуулийн 14 дүгээр зүйлд “Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд хяналт тавих, соёлын эрэлт хэрэгцээг хангах, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх”-ийг заасан байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасны дагуу шалгуур хангагдсан соёлын өвийг иргэдээс үнэ төлбөргүй хүлээн авдаг ба үнэгүй тул бүртгэгддэггүй байдал ажиглагдлаа. Энэ нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “Соёлын өвийн үнэлгээ”, 9 дүгээр зүйлийн 9.1-д “Соёлын өвийн үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална”, 9.2-т “Нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээг төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх “Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох зөвлөл” тодорхойлно”, 9.3-д “Хувийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээг өмчлөгчийн хүсэлтээр 9.2-д заасны дагуу тодорхойлж болно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахгүй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Монголын театрын музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар музейн үзмэрт орсон өөрчлөлт хөдөлгөөн, орлогыг төрөл зүйлээр нь нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Монголын театрын музейн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 81,506.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 22,034.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,676.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн 1 акт тогтоож, 56,795.9 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монголын театрын музейн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн байна. Өгөгдсөн 1 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.


2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Монголын театрын музейн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 188,599.8 мянган төгрөг бөгөөд 2.0 хувиар буюу 3,771.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Дээрх алдаа зөрчлийн улмаас Монголын театрын музейн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлээгүй тул “Сөрөг” санал дүгнэлт өгч байна.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монголын театрын музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Худалдан авалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд нийт 60,090.7 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 3,294.7 мянган төгрөгийн НӨАТ-ын цахим баримт бүрдүүлж, 56,795.9 мянган төгрөгийн худалдан авалтад НӨАТ-ын цахим баримт бүрдүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн болон НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлэн ажиллах, худалдан авалтад НӨАТ-ын цахим баримт бүрдүүлэх.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн болон НӨАТ-ын хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдлүүд зөрчигдөх;

Төсвийн захирагчийн хариу


Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,055,831.00	872,258.00
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	-
	АВЛАГА	2,073.00	-
	Ажиллагсадтай холбогдсон авлага	2,073.00	-
	БАРАА МАТЕРИАЛ	1,053,758.00	872,258.00
	Бэлэн бүтээгдэхүүн	181,500.00	-
	Хангамжийн материал	872,258.00	872,258.00
	Аж ахуйн материал	872,258.00	872,258.00
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	811,703,137.46	811,710,064.55
	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	811,703,137.46	811,710,064.55
	Биет хөрөнгө	811,087,357.50	811,162,704.63
	Машин, тоног төхөөрөмж	13,878,873.00	13,878,873.00
	Хуримтлагдсан элэгдэл	(4,163,661.36)	(5,551,548.72)
	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,727,018.73	43,727,018.73
	Хуримтлагдсан элэгдэл	(22,676,274.97)	(26,202,823.73)
	Түүх соёлын дурсгалт зүйлс	776,169,020.00	778,669,020.00
	Бусад үндсэн хөрөнгө	18,718,984.00	22,108,873.75
	Хуримтлагдсан элэгдэл	(16,076,601.90)	(16,976,708.40)
	Номын фонд	1,510,000.00	1,510,000.00
	Биет бус хөрөнгө	615,779.96	547,359.92
	Програм хангамж	684,200.00	684,200.00
	Хасагдуулга	(68,420.04)	(136,840.08)
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	812,758,968.46	812,582,322.55
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
	Өглөг	0.00	0.00
	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	0.00
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	812,758,968.46	812,582,322.55
	Засгийн газрын хувь оролцоо	812,758,968.46	812,582,322.55
	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	70,433,859.73	70,433,859.73




Өмч: -Төрийн өмч	70,433,859.73	70,433,859.73
Хуримтлагдсан үр дүн	21,605,175.73	21,428,529.82
Өмнөх үеийн үр дүн	21,605,175.73	21,605,175.73
Тайлант үеийн үр дүн	-	(176,645.91)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	720,719,933.00	720,719,933.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	812,758,968.46	812,582,322.55



4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	137,824,700.00	188,423,189.75
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,559,500.00	5,547,889.75
Нийтлэг татварын бус орлого	3,559,500.00	5,547,889.75
Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,559,500.00	5,547,889.75
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,049,500.00	2,158,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,510,000.00	3,389,889.75
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	134,265,200.00	182,875,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	134,265,200.00	150,525,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	134,265,200.00	150,525,300.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	32,350,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	32,350,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	152,057,868.34	188,599,835.66
УРСГАЛ ЗАРДАЛ	151,769,252.17	171,151,335.66
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,769,252.17	171,151,335.66
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	97,200,099.73	96,546,373.00
Цалин	87,738,173.73	86,583,500.00
Унаа хоолны хөнгөлөлт	4,961,200.00	5,365,100.00
Гэрээтийн цалин	4,500,726.00	4,597,773.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,726,487.00	10,949,800.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,508,179.00	6,968,055.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	766,307.00	995,436.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	486,000.00	796,350.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	972,000.00	199,087.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	1,994,001.00	1,990,872.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,190,500.00	20,978,400.00
Байрны түрээс	21,190,500.00	20,978,400.00
Хангамж, бараа материалын зардал	5,554,952.10	1,684,200.00
Бичиг хэргийн материал	133,000.00	131,800.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	1,005,632.10	896,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	4,416,320.00	656,400.00
Нормативт зардал	249,500.00	247,500.00



Нормын хувцас, зөөлөн эдлэл	249,500.00	247,500.00
Эд хогшил, урсгал засварын зардал	102,800.00	30,094,100.00
Урсгал засвар	102,800.00	30,094,100.00
Томилолт, зочны зардал	88,000.00	130,000.00
Дотоод томилолтын зардал	88,000.00	130,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,684,200.00	4,638,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,184,200.00	4,143,000.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	500,000.00	495,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	11,972,713.34	5,882,962.66
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,972,713.34	5,882,962.66
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	288,616.17	17,448,500.00
Бусад урсгал шилжүүлэг	-	17,447,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	14,447,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	3,000,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	288,616.17	1,500.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	288,616.17	1,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(14,233,168.34)	(176,645.91)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,376,084.20	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,376,084.20	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(1,376,084.20)	-
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(15,609,252.54)	(176,645.91)



4.4 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2017 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	136,314,700.00	185,033,300.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,049,500.00	2,158,000.00
Нийтлэг татварын бус орлого	2,049,500.00	2,158,000.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,049,500.00	2,158,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,049,500.00	2,158,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	134,265,200.00	182,875,300.00
Улсын төвлөрсөн төсвөөс	134,265,200.00	150,525,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	134,265,200.00	150,525,300.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	32,350,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	-	32,350,000.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	136,314,700.00	185,033,300.00
УРСГАЛ ЗАРДАЛ	136,314,700.00	185,033,300.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,026,083.83	167,584,800.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	97,312,172.73	96,544,300.00
Үндсэн цалин	87,850,246.73	86,583,500.00
Унаа хоолны хөнгөлөлт	4,961,200.00	5,365,100.00
Гэрээт ажлын хөлс	4,500,726.00	4,595,700.00
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	10,726,487.00	10,949,800.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	6,558,179.00	6,968,055.00
